



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар A/184

Улаанбаатар хот

**Газар эзэмших, ашиглах эрхийн
гэрчилгээг худалдаж авах эрхийг
цуцлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 12.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн Засаг даргын 2025 оны A/131 дүгээр захирамжаар 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдөр газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулахад 2 дугаар хороо, Хуучин нүүрсний уурхай баруун урд талд байршилтай 27.3773 га газрын эзэмших эрхийн ялагчаар шалгарсан Н.Нардамба нь үлдэгдэл төлбөр болох 500,386,053 төгрөгийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу хугацаандаа төлөөгүй тул газар эзэмших эрхийн гэрчилгээг худалдаж авах эрхийг цуцлан, дэнчинд төлсөн мөнгийг Улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг худалдаж авах эрхийг хүчингүй болгосонтой холбогдуулан дээрх байршилд хууль, журмын дагуу дуудлага худалдааг дахин зохион байгуулахыг Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД